



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/08/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжнэ хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Хаяхны мууруу: govaltai@audit.gov.mn
Хаяхны хаяг: www.audit.mn

2023.02.15

№

119

Танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Солонго дулааны станц" ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Солонго дулааны станц" ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар амралт цалин давхардуулсан, өглөгийг барагдуулаагүй, орлогын төлөвлөгөөг тасалсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, тендерт шалгараагүй этгээдээс худалдан авалт хийсэн, тээвэр шатахууны зардлыг зориулалт бусаар зарцуулсан, ЖДҮДС-аас авсан зээл, алдангийг төлөөгүй, тээврийн хөлсийг анхан шатны баримтгүй зарцуулсан, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг 363.4 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны 898.5 сая төгрөгийн орлого, 1,120.8 сая төгрөгийн зардал, 222.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

07020000776

Гүйцэтгэлээр 857.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 30.0 сая төгрөгийн дэмжлэг авч, 1,325.9 сая төгрөгийн зардал гарган, 438.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 06/210 дугаартай албан шаардлага, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 01/160, 02/160, 04/160, 06/160 дугаартай албан шаардлага, "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг" гүйцэтгэлийн 2022 оны аудитын 03/188 дугаартай төлбөрийн акт, 27/199 дугаартай албан шаардлага хэрэгжээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**(мянган төгрөг)**

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	251,584.78	267,336.90
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,260,624.09	9,866,557.86
	Нийт хөрөнгийн дүн	10,512,208.88	10,133,894.76
	Нийт өр төлбөрийн дүн	244,208.85	304,055.06
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,268,000.03	9,829,839.70
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,512,208.88	10,133,894.76
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	(52,927.52)	(285,193.54)
	Үйл ажиллагааны зардлын дүн	96,986.89	152,966.79
	Үйл ажиллагааны үр дүн	(149,914.41)	(438,160.32)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(149,914.41)	(438,160.32)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,166,345.82	10,268,000.03
	Тайлант оны үр дүн	(149,914.41)	(438,160.32)
	Эцсийн үлдэгдэл	10,268,000.03	9,829,839.70
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	842,533.07	919,431.87
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	718,570.48	901,284.15
	Үйл ажиллагааны ЦМГ	123,962.59	18,147.72
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(44,299,999.99)	(16,969,200.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(79,831,128.32)	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(168,536.56)	1,178,519.95
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	815,217.88	646,681.32
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	646,681.32	1,825,201.27

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 137.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 137.9 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 363.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, өмнөх шийдвэр хэрэгжүүлээгүйд 1 хариуцлага тооцох албан шаардлага, 362.9 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 8 заалт албан шаардлага хүргүүлсэн.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Амралт цалин, давхардуулан 0.3 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн хууль зөрчин тээвэр шатахууны зардлаас 0.3 сая төгрөгийн мөсний баярт зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Орлогын төлөвлөгөөг 40.7 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тус байгууллага нь ЖДҮДС-аас 2019 онд авсан 150.0 сая төгрөгийн зээлээс 37.2 сая төгрөгийг, алданги хүү торгуулийн 8.0 сая төгрөгийг төлөөгүй байгаа нь Аймгийн Засаг даргатай 2019 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 01 дугаартай "Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгох зээлийн гэрээ"-ний 3 дугаар зүйлийн "3.7-т Зээлдэгч зээлийг сар бүрийн хуваарьт хоногийн ажлын өдөрт багтаан аймгийн төрийн сан дахь аймгийн жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн 100050051402 тоот бүртгэлийн дансанд төлнө; 9 дүгээр зүйлийн 9.3-т Зээлдэгч нь зээлийг зориулалт бусаар ашигласан, зээлийн төлбөрийг зээл буцаан төлөх хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөөгүй нь хяналт шалгалт хийх эрх бүхий ажлын хэсгийн шалгалтаар тогтоогдвол гэрээг цуцлах, тухайн банкны арилжааны зээлд шилжүүлэх, зээлийг эргүүлэн төлүүлэх, дахин зээлд хамруулахгүй байх үндэслэл болно;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тендерт шалгараагүй этгээдээс 164.8 сая төгрөгийн нүүрс худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил%, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Сэлбэг хэрэгсэл худалдан авахад 1.7 сая төгрөгийн тээврийн хөлсийг гэрээгүй, анхан шатны баримт хангалтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Худалдан авах ажиллагаа зарлалгүй 21.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил%, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдэлтэй 8 байгууллагын 88.8 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага

- ✓ Өмнөх оны аудитаар өгсөн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 06/210 дугаартай албан шаардлага, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 01/160, 02/160, 04/160, 06/160 дугаартай албан шаардлага, "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг" гүйцэтгэлийн 2022 оны аудитын 03/188 дугаартай төлбөрийн акт, 27/199 дугаартай албан шаардлага хэрэгжээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Солонго дулааны станц ААТҮГ	1	137.9	1	137.9			1	137.9	-	-	-	-
Дүн	1	137.9	1	137.9			1	137.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Солонго дулааны станц ААТҮГ	10	363.4	2	0.5	7	362.9	-	-	1	-	-	-
Дүн	10	363.4	2	0.5	7	362.9	-	-	1	-	-	-

1Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-